



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/08

Эмээлтолгой

Өвс актлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Сумын Засаг даргын Тамгын газрын өвч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 17-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Засаг даргын Тамгын газрын өвс тэжээлийн агуулахад байсан хөгцөрч муудсан, мод ихтэй, цаашид ашиглах боломжгүй болсон 12,607,000 (Арван хоёр сая зургаан зуун долоон мянган) төгрөгний үнэ бүхий 686 боодол өвсийг акталсугай.

2.Актлах өвсийг нүдээр үзэж, баримтжуулж устгахыг Нягтлан бодогч (Д.Баттөр), Нярав (Б.Буян-Арвижих) нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Азжаргал)-д даалгасугай.



ДАРГА Б.ӨНӨРБАЯР

